



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох,
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 8 дугаар зүйлийн 8.1.13, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл шинээр хүссэн “Мөнхийн Чансаа” ХХК-ийн “Энх Амьдрал” эмэгтэйчүүдийн хавдрын үүдэн эмнэлэгт 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Баян-Адарга суманд үйл ажиллагаа явуулж буй “Ариун Наран Тун” ХХК-ийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай сунгасугай.
3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд), Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (О.Энх-Уянга) нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.МЭНДБАЯР